



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 05 сарын 11 өдөр

Дугаар

А/110

Мандалговь

“Цахим төр-ухаалаг Дундговь”  
цахим систем хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх  
ажлын хэсэг байгуулах тухай

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт 4.1, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл төлөвлөгөөний 5.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан “Цахим төр-ухаалаг Дундговь” цахим систем хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Түвшинжаргал (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Ц.Одончимэг (Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсийн нутгийн удирдлагын байгууллагын шийдвэр, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн)

Ж.Уянга (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Эдийн засаг, төлөвлөлтийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн)

Б.Болор-Эрдэнэ (Нийгмийн бодлогын хэлтсийн Соёл урлаг, спортын бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн)

Н.Сүхбаатар (Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

С.Цэнгэлмаа (Хууль, эрх зүйн хэлтсийн эрх зүйн сургалт, сурталчилгаа, авилгаас урьдчилан сэргийлэх бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн)

Д.Даариймаа (Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсийн хэтийн зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн)

Б.Пэрэнлэймаа (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн нутгийн захиргааны байгууллага, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн)

Н.Мөнгөн (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Мэдээллийн технологийн ажилтан)

Нарийн бичгийн дарга:

Г.Самданцоодол (Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга)

2. Цахим системийг хөгжүүлэхэд шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлж, цаг хугацаанд нь нэвтрүүлж, нутагшуулах ажлын зохион байгуулалттай явуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Н.Түвшинжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ДОРЖБАТ

4822150239